

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ-ЫН САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ЭХНИЙ 5 САРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
1	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох гүйлгээ, тайлан мэдээ, тушаал шийдвэрийг стандарт, журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд оруулж байршуулна.	Мэдээллийг ойлгомжтой байдлаар цахимд байршуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн дагуу дараах мэдээллийг цаг хугацаанд нь оруулж баталгаажуулан ажилласан. Үүнд: ➢ 2023 оны эхний 5 сарын байдлаар 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий мөнгөн хөрөнгийн нийт 302 гүйлгээ шивснээс орлогын 178 гүйлгээ буюу 11,424.6 сая төгрөг, зарлагын 124 гүйлгээ буюу 9,820.2 сая төгрөг ➢ Тендерийн сэлбэг материал худалдан авах 9,206.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 ажил үйлчилгээ ➢ Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин ➢ Байгууллагын 2022 оны санхүүгийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр Хэрэгжилт 100 хувь
2	Байгууллагын аудитлагдсан санхүүгийн тайланг шилэн дансны болон өөрийн байгууллагын цахим хуудсанд мэдээлнэ.	Мэдээллийг ойлгомжтой байдлаар цахимд байршуулах	2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг “Бэст Фортуна” ХХК гүйцэтгэж санхүүгийн ажилтнуудын зүгээс санхүүгийн тайлан мэдээ, баримтыг шаардсан тухай бүр гарган өгч хамтран ажиллаж санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтаар Нийслэл дэх төрийн аудитын газраас “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлттэй Аудитын гэрчилгээг 2023 оны 03 сарын 15-нд олгосон. Шилэн дансны хуулийн дагуу аудитлагдсан санхүүгийн тайланг шилэн дансанд болон байгууллагын цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулсан. Хэрэгжилт 100 хувь.
3	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны судалгаа	Мэдээллийг ойлгомжтой	

	шинжилгээ, дүгнэлт, статистик мэдээ тайланг байнга гаргаж баримт мэдээлэлийг архив үүсгэн хадгална.	байдлаар танилцуулах	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны үр дүн болон тухайн цаг үед шаардагдах мэдээ тайлан, судалгаа шинжилгээг гаргаж удирлагыг мэдээлэлээр хангаж ажиллалаа. Нийслэлийн тээврийн газарт сар улирал, хагас бүтэн жилээр тээвэрлэлтийн тайлан, санхүү эдийн засгийн үзүүлэлт зэргийг хуулийн хугацаанд нь гаргаж өгсөн. Хэрэгжилт 100 хувь.
--	---	----------------------	---

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Б.БАЯРЦЭЦЭГ

